



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2026. 02.24 № 1/338

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажилд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу үнийн санал ирүүлнэ үү.


Үнийн саналыг 2026 оны 03 дугаар сарын 03-ны 12:00 цаг хүртэл хүлээн авна.

Мэйл хаяг: procurement@fchm.edu.mn

Хаяг: Захиргааны 503 тоот

Хавсралт 2 хуудастай.

**ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ**




П.АНХТУЯА

ATA9996 9097136
9023050128

142260546

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий
захирлын 2026 оны 1338 дугаар сарын 24-ны
өдрийн 1338 дугаар албан бичгийн хавсралт



САНХҮҮГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ерөнхий зорилго:

Санхүүгийн үйл ажиллагаанд иж бүрэн дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааг сайжруулах болон орлогыг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээний зөвлөмж боловсруулна.

Үнэлгээний зорилт

- Санхүүгийн тайлан, тэнцэл, орлого-зарлагын бүтцийг задлан шинжлэх
- Орлогын эх үүсвэр, зарцуулалтын үр ашиг, хэмнэлтийн нөөцийг тодорхойлох
- Санхүүгийн эрсдэл, хөрвөх чадвар, хариуцлагын байдалд үнэлгээ өгөх
- Орлого нэмэгдүүлэх болон зардал хэмнэх боломжит арга замыг судлах
- Эмнэлгийн санхүүгийн удирдлагын тогтолцоо, дотоод хяналтын байдлыг үнэлэх
- Стратегийн болон санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих зөвлөмж боловсруулах

ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

Цаг хугацааны хүрээ

Үнэлгээнд 2023–2025 оны гурван (3) жилийн санхүүгийн мэдээлэл хамрагдана.

Агуулгын хүрээ

- Баланс, орлого-зарлагын тайлан, мөнгөн урсгалын тайлан
- Төсвийн хуваарилалт, зарцуулалт, гүйцэтгэл
- Хүний нөөцийн зардлын бүтэц
- Байгууллагын өртгийн тооцоололд үндэслэн гаргасан тасаг, нэгжийн харьцаа
- Тоног төхөөрөмж, хөрөнгийн элэгдэл, шинэчлэлтийн байдал
- Авлага, өглөгийн удирдлага
- Эрүүл мэндийн дэмжих төвийн хүчин чадал, ашиглалтыг сайжруулалт

ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Байгууллагын шаардлага

- Монгол Улсад хуулийн этгээдээр бүртгэгдсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чадамж бүхий байгууллага байх
- Эрүүл мэндийн байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байх

Мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага

- Ахлах санхүүгийн шинжээч: санхүү бизнесийн удирдлагын чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй, 7+ жилийн туршлагатай, ажлын даалгаварт тусгагдсан ажлыг нэгтгэн дүгнэх чадамж бүхий байх

- Эрүүл мэндийн эдийн засагч: эрүүл мэндийн санхүүжилтийн чиглэлээр 10+ жилийн туршлагатай, ажлын даалгаварт тусгагдсан ажлыг гүйцэтгэх чадамж бүхий байх

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1. Захиалагч байгууллагатай хамтран ажиллах нарийвчилсан ажлын төлөвлөгөө боловсруулах
2. Шаардлагатай санхүүгийн баримт бичиг, мэдээллийг цуглуулах, баталгаажуулах
3. Холбогдох нэгжийн дарга, нягтлан бодогч, удирдлагатай ярилцлага хийх, нэмэлт мэдээлэл цуглуулах
4. Санхүүгийн дүн шинжилгээ хийж завсрын тайлан боловсруулах
5. Байгууллагын 2025 оны төсвийн гүйцэтгэлд үндэслэн өртгийн тооцоолол хийхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх
6. “Эрүүл мэндийн дэмжих төв”-ийн хүчин чадлын тооцооллыг хийх, үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг тодорхойлох
7. Хэрэгжүүлэх боломжтой, тодорхой зөвлөмжийн матриц боловсруулах

----- ooo OOO ooo -----

Эрүүл мэндийн эдийн засагч: эрүүл мэндийн санхүүжилтийн чиглэлээр 10+ жилийн туршлагатай, ажлын даалгаварт тусгагдсан ажлыг гүйцэтгэх чадамж бүхий байх